


БАТЛАВ.
НИЙСЛЭЛИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН
ЗАХИРГАА, ТӨЛӨВЛӨЛТ, УДИРДЛАГЫН
ХЭЛТСИЙН ДАРГА У.БАТ-ОЧИР



2025 оны 01 дүгээр сарын 20-ны өдөр

Улаанбаатар хот


НИЙСЛЭЛИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН АЛБАН ХААГЧДЫН СУРГАЛТ,
АЖИЛЛАХ НӨХЦӨЛ, НИЙГМИЙН БАТАЛГААГ ХАНГАХ ХӨТӨЛБӨРИЙН
2025 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Хэрэгжүүлэх үйл ажиллагаа	Шалгуур үзүүлэлт
Зорилт 1. Албан хаагчдын нийгмийн баталгааг хангах, цалин хөлс, тусламж, шагнал урамшууллыг хууль тогтоомжийн дагуу олгож, үр бүтээлтэй, тогтвор суурьшилтай ажиллуулах чиглэлээр:		
1.	Улсын Их Хурал, Засгийн газраас баталсан цалингийн сүлжээг баримтлан төрийн албан хаагчдын цалин, урамшуулалыг тухай бүр нь шинэчлэн тогтоож олгох	Албан хаагчдын цалин, нэмэгдлийг тухай бүр нь шинэчлэн тогтоож олгогдсон байна.
2.	Албан хаагчдад сар бүр унаа хоолны хөнгөлөлтийг олгох	Сар бүр унаа хоолны хөнгөлөлт олгогдсон байна.
3.	Гэр болон галлагаатай байшинд амьдардаг албан хаагчдад түлээ, нүүрс худалдан авахад байгууллагаас санхүүгийн дэмжлэг үзүүлэх	Санхүүгийн дэмжлэг үзүүлсэн байна.
4.	Албан хаагчдын ажлын гүйцэтгэлийг дүгнэж, хууль тогтоомжид заасны дагуу урамшууллыг олгох	Хууль тогтоомжид заасны дагуу урамшуулал олгогдсон байна.
5.	Албан хаагчдад зэрэг дэвийн нэмэгдэлийг олгуулах	Албан хаагчдын зэрэг дэв нэмэгдсэн байна.
Зорилт 2. Албан хаагчдын ажиллаж, амьдрах орчин нөхцлийг сайжруулах, орон байраар хангахад дэмжлэг үзүүлэх чиглэлээр:		

1.	Шинээр ажилд томилогдсон албан хаагчид байгууллагын чиг үүрэг, бүтэц, зохион байгуулалт, албан тушаалын тодорхойлолт, дотоод журам болон төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль зэрэг шаардлагатай мэдээллийг танилцуулж хэвших	Албан хаагчдыг мэдээллээр хангасан байна.
2.	Албан хаагчдын ажлаас нь хөндийрүүлэхгүйгээр сургалтад хамруулах, дотоод сургалтын төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлэх	Төлөвлөгөө батлагдаж, хэрэгжилт хангагдсан байна.
3.	Гэр хороололд амьдардаг албан хаагчдын судалгааг гаргаж, түрээсийн орон сууц, ипотекийн хөнгөлөлттэй зээлд дугаарын дараалалгүй хамруулах	Албан хаагчид төрөөс хэрэгжүүлж буй хөнгөлөлттэй нөхцөлийн байр, орон сууцны зээлэнд хамрагдсан байна.
4.	Албан хаагчдад цалингийн зээлийн хүүгийн хөнгөлөлт эдлүүлэх	Албан хаагчид цалингийн хөнгөлөлттэй нөхцөлийн зээлийн үйлчилгээнд хамрагдсан байна.
5.	Ажлын байрны тохижилтын үйл ажиллагааг үе шаттай зохион байгуулж, ая тухтай ажиллах нөхцлийг бүрдүүлэх	Албан хаагчдын ая тухтай ажиллах нөхцөл бүрдэж, сэтгэл ханамж дээшилсэн байна.
Зорилт 3. Албан хаагчдын эрүүл мэндийг хамгаалах, эрүүл мэндийн үзлэгийн чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх		
1.	Албан хаагчдын эрүүл мэндийн үзлэгт хамруулах	Албан хаагчид эрүүл мэндийн үзлэгт хамрагдсан байна.
Зорилт 4. Албан хаагчдын амралт, чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх нөхцөл боломжоор хангах, ажиллах идэвх санаачлага, сэтгэл ханамжийг нэмэгдүүлэх		
1.	Албан хаагчдаа өвчлөхөөс урьдчилан сэргийлэх зорилгоор ажлын байрны эрүүл ахуйн нөхцлийг сайжруулах, спортын уралдаан тэмцээн зохион байгуулах арга хэмжээг тогтмолжуулах	Уралдаан тэмцээн тогтмол зохион байгуулагдсан байна.
2.	Ажлын байрны тохижилтын үйл ажиллагааг үе шаттай зохион байгуулж, ая тухтай ажиллах нөхцлийг бүрдүүлэх	Албан хаагчдын ая тухтай ажиллах нөхцөл бүрдэж, сэтгэл ханамж дээшилсэн байна.

ТӨЛӨВЛӨГӨӨ ГАРГАСАН:

БАЙГУУЛЛАГЫН ХҮНИЙ НӨӨЦИЙН АСУУДАЛ ХАРИУЦСАН
АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН



М.ОЮУН-ЭРДЭНЭ